



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/503

Мөрөн сум

Гэрээ байгуулах эрх олгож, захиалагчийн  
төлөөлөгч томилж, ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дүгээр зүйлийн 30.1, 48 дугаар зүйлийн 48.2.6, 48.2.7, 48.2.9, Засгийн газрын 2023 оны “Журам батлах тухай” 278 дугаар тогтоол, Сангийн сайдын 2023 оны “Бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг батлах тухай” А/258 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны “Байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүрэг батлах тухай” А/95 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр батлагдсан Сумын төвийн шаардлага хангасан гэрэлтүүлэгтэй болгон аюулгүй байдлыг хангах /Бүрэнтогтох сум/ ажлын гүйцэтгэгч сонгох төсөл арга хэмжээнд ХӨАХААГ/20240201079 дугаартай 72,427,948 (Далан хоёр сая дөрвөн зуун хорин долоон мянга есөн зуун дөчин найм) төгрөг төгрөгийн үнийн санал ирүүлсэн “Хөвсгөл Мөнгөн Од” ХХК-ийн тендерийг зөвшөөрч, тус компанид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсүгэй.

2. “Хөвсгөл Мөнгөн Од” ХХК-тай гэрээтэй холбоотой асуудлаар захиалагчийг төлөөлж харилцах, холбогдох шийдвэрийг гаргах, ажлын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, үе шатны хяналт хэрэгжүүлэх этгээдтэй гэрээ байгуулах дүгнэх чиг үүрэг бүхий “Захиалагчийн төлөөлөгч”-өөр аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-г томилж, ажил, үйлчилгээ хүлээн авах, нийлүүлэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Захиалагчийн төлөөлөгч:

Б.Оюунтуяа

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө  
оруулалтын хэлтсийн дарга)

Ажлын хэсгийн гишүүд:

Б.Цэнддэлгэр

(Аймгийн Орон нутгийн өмчийн газрын  
Өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан  
ахлах мэргэжилтэн)

Б.Гал-Эрдэнэ

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө  
оруулалтын хэлтсийн Харилцаа холбоо  
хяналтын улсын байцаагч)  
("Хөвсгөл Мөнгөн Од" ХХК-ийн захирал)

Б.Баярмөнх

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Д.Сандагдорж

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө  
оруулалтын хэлтсийн Дэд бүтцийн  
бодлого үйл ажиллагааг зохион  
байгуулах мэргэжилтэн)

3. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр батлагдсан Сумын төвийн шаардлага хангасан гэрэлтүүлэгтэй болгон аюулгүй байдлыг хангах /Бүрэнтогтох сум/ төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэгч сонгох гэрээнд заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх, ажлын гүйцэтгэлд үе шатанд хийх захиалагчийн хяналтыг "Хөвсгөл Мөнгөн Од" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх, уг гэрээг дүгнэх, ил далд ажлын акт, ажлын гүйцэтгэлийг тус тус баталгаажуулах, гэрэлтүүлгийг ашиглалтад оруулахад шаардлагатай баримт бичгийг бэлтгэж аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүргүүлэх, гэрээ болон гэрээний хэрэгжилтийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх цогц системд тус тус нийтлэх, захиалагчийн төлөөлөгчийн чиг үүрэг хэрэгжүүлсэн ажлын үр дүнгийн тайлан гэрэлтүүлгийн ажлын гэрээний хэрэгжилттэй холбоотой баримт бичгийг архивын нэгж болгон Худалдан авах ажиллагааны газрын архивд шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг ажлын хэсэг (Б.Оюунтуяа)-д, захиалагч, тендерт оролцогч (тухайн тендерт оролцсон нийт оролцогч)-ийн тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан баримт бичиг, гэрээт ажлын үе шатны хяналтыг хийж, баталгаажуулсан техник хяналтын нэгдсэн дүгнэлт, зохиогчийн дүгнэлт, авто замын ашиглалтад хүлээн авсан шийдвэр, санхүүжилтийн гүйцэтгэл зэрэг баримт бичгийг цахим болон бичгийн хэлбэрээр архивлан Худалдан авах ажиллагааны газрын архивд шилжүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Д.Төмөр)-д тус тус даалгасугай.

4 Сумын төвийн шаардлага хангасан гэрэлтүүлэгтэй болгон аюулгүй байдлыг хангах /Бүрэнтогтох сум/ гүйцэтгэгч сонгоход хэрэгжүүлэх шаардлагатай зардлыг гэрээний дагуу "Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв" ОНӨААТҮГ-т Сумын төвийн шаардлага хангасан гэрэлтүүлэгтэй болгон аюулгүй байдлыг хангах /Бүрэнтогтох сум/ төсөл арга хэмжээний ажлыг ашиглалтад хүлээн авах ажиллагаатай холбогдон гарах зардлыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт шилжүүлэхийг Худалдан авах ажиллагааны газар (Б.Должинсорогдог)-т тус тус зөвшөөрсүгэй

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсорогдог)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ